



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/16

Чойр

“Аймгийн Засаг даргын шагналын  
журам”-ыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Засгийн газрын 1997 оны “Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай” 54 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 02 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Аймгийн Засаг даргын шагналын журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Журмын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном) үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны А/20, 2021 оны А/411 дүгээр захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Г.БАТЗАМ

Аймгийн Засаг даргын 2022 оны 01.  
дугаар сарын 19-ны өдрийн 416 дугаар  
захирамжийн хавсралт

## АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШАГНАЛЫН ЖУРАМ НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Аймгийн Засаг даргаас олгох шагналын төрөл, болзол, тавигдах шаардлага, шагналд нэр дэвшүүлэх, уламжлах, өргөн мэдүүлэх, түүнийг хүлээн авч судлах, шийдвэрлэх, шагналыг гардуулахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Аймгийн төрийн захиргаа, нийгэм, эдийн засаг, хөдөө аж ахуй, соёл урлаг, спорт болон бусад салбарыг хөгжүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулж, идэвх санаачилга, үр бүтээлтэй ажилласан ажилтан, албан хаагч, иргэд, байгууллага, хамт олныг энэ журмын дагуу шагнаж, урамшуулна.

### ХОЁР. ШАГНАЛЫН ТӨРӨЛ

2.1. Аймгийн Засаг даргаас олгох шагнал нь дараах төрлүүдтэй байна. Үүнд:

- 2.1.1. Аймгийн “Хүндэт дэвтэр”-т бичигдсэн дурсгалын гэрчилгээ;
- 2.1.2. Аймгийн “Аварга малчин” цол, тэмдэг;
- 2.1.3. Аймгийн “Алдарт уяач” цол, тэмдэг;
- 2.1.4. Аймгийн “Оны онцлох байгууллага”;
- 2.1.5. Аймгийн “Оны онцлох хүн”;
- 2.1.6. Аймгийн Засаг даргын “Жуух бичиг”;

### ГУРАВ. ШАГНАЛ ОЛГОХ БОЛЗОЛ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

3.1. Аймгийн Засаг даргын шагналд тодорхойлогдож байгаа нэр дэвшигч нь дор дурдсан болзол, шалгуурыг хангасан байна. Үүнд:

#### 3.1.1. Аймгийн “Хүндэт дэвтэр”-т бичиж, дурсгалын гэрчилгээ олгох;

Монгол Улсын баатар, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Монгол Улсын Ардын болон Гавьяат цолтон, Төрийн шагнал хүртсэн болон орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж, хөдөлмөрийн өндөр амжилт, үр бүтээл гаргасан иргэдийн нэрийг бичиж алдар гавьяа, сайн үйлс, үлгэр дууриалыг алдаршуулж, аймгийн “Хүндэт дэвтэр”-т бичиж дурсгалын гэрчилгээ хадгалуулна.

#### 3.1.2. Аймгийн “Аварга малчин” цол, тэмдэг;

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх, мал маллагааны уламжлалт аргыг боловсронгуй болгох, малын үүлдэрлэг байдал чанарыг сайжруулан ашиг шимийг нэмэгдүүлэх, малаа мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өсгөх болон малгүй өрхийг малжуулах, малчдын нийгэмд оруулж байгаа хувь нэмрийг үнэлж малчин өрхийн тэргүүн болон эхнэрийг “Аварга малчин” үнэмлэх тэмдэгээр шагнана.

Мал сүргээ жилийн дөрвөн улиралд уламжлалт аргаар өөрөө малладаг, мал маллагааны туршлагаа залуу малчдад зааж сургаж шавь малчинтай болсон, туслах малчинтай гэрээ байгуулсан байх, орон нутагт ажлын байр бий болгож ядуурлыг бууруулахад бодит хувь нэмэр оруулсан байх;

Өөрийн эзэмшлийн өвөлжөө, хаваржааны хашаа, худагтай, мал аж ахуйн үйлдвэрлэлээс олсон орлогоос доройтсон бэлчээрийг сайжруулах, худаг гаргах, булаг, шандны эхийг хамгаалах, мод тарих, ногоон байгууламж бий болгоход зарцуулсан байх

Өвөлжөө, хаваржааныхаа бэлчээрийг гэргээгээр ашигладаг, бэлчээрийн даацад малын тоог тохируулан сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний дагуу бэлчээрийг сэлгэн өнжөөх, отор, нүүдэл хийж зохистой ашигладаг, бэлчээрийн хортон мэрэгч, шавжтай энгийн механик болон микробиологийн аргаар тэмцэх ажилд идэвхтэй оролцдог байх

Ашиглагдахгүй байгаа алслагдсан бэлчээрийг ашиглан отор нүүдэл хийж малдаа тарга хүч авахуулсан, сумын тухайн жилийн бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний дагуу бэлчээрийг ашиглаж зөрчил гаргаагүй байх, өвлийн бэлтгэл хангах ажилд манлайлан шаардлагатай өвс, тэжээлийн нөөц бүрдүүлсэн байх

Тухайн бүс нутгийн байгаль, цаг уурын онцлогт тохирсон төрөл, үүлдэр, омгийн малыг өсгөн үржүүлдэг, малын чанарыг сайжруулж, сүргийн зохистой бүтцийг бүрдүүлсэн байх; мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжтэй гэрээ байгуулан, жил бүр үржлийн малын үзлэг ангилалтыг технологит хугацаанд хийлгэсэн байх;

Нийт малаа ялган тэмдэглэж бүртгэлжүүлсэн, бог малын хээлтүүлэгчийг мал үржүүлэг технологийн нэгжид шилжүүлсэн, үржлийн малын удам гаргалийн гэрчилгээг сумын хөдөө аж ахуйн тасгөөс авсан байх

Сүрэгт эзлэх хээлтэгчийн тоо сүүлийн 3 жил дараалан тогтвортой өссөн, хээлтэгч нь бог малд 55, бод малд 40 болон түүнээс дээш хувьд хүрсэн, тухайн тугат үржүүлж байгаа үүлдэр, омгийн малын ашиг шимийн үзүүлэлтийг нэс, хүйсээр хангасан, сүргийн бүтцийг зохистой түвшинд хангасан, бодод шилжүүлснээр 100-аас доошгүй толгой малтай, сумын ХХ-н тасагтай хамтран ажилласан байх /сумын ХАА-н тасгийн тодорхойлолт, дүгнэлттэй/

Малаа мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тогтмол бүрэн хамруулж, малын эрүүл мэндийн дэвтэр хөтөлдөг, сүүлийн 3 жилд мал сүрэгт нь малын гоц халдварт болон халдварт өвчин гаргаагүй, малын зүй бус хорогдолгүй, сумын мал эмнэлгийн тасагтай хамтран ажилласан байх /сумын мал эмнэлгийн тасгийн тодорхойлолт дүгнэлт/

Малчин өрхийн гишүүд нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд даатгуулж, малаа малын индексжуулсан даатгалд даатгуулсан байх

Сүрэгт эзлэх таваарын малын 30-аас доошгүй хувийг жил бүр эдийн засгийн эргэлтэд оруулсан байх; /бусдаас худалдсан болон бэлгэнд авсан мал, бүтээгдэхүүнийг оруулж тооцохгүй/

Шагналд тодорхойлогдож буй малчин нь гэмт хэрэгт холбогдож байгаагүй, бэлчээр ашиглалтын зөрчил гаргаагүй, малын тоо толгойн албан татварыг тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоосон хэмжээгээр бүрэн төлсөн байх;

**3.1.3.Аймгийн “Алдарт уяач” цол, тэмдгийг доорх болзол хангасан уяач нарт олгоно.**

Монгол Улсын үндэсний их баяр наадамд уяж, сойсон хурдан хүлэг морь нь түрүүлж, айрагдсан, Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор зохион байгуулагдаж байгаа бүсийн хурдан морины уралдаанд уяж, сойсон хурдан хүлэг морь нь түрүүлсэн уяач нарт,

Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор зохион байгуулагдаж байгаа бүсийн хурдан морины уралдаанд уяж, сойсон хурдан хүлэг морь нь айрагдаж, аймгийн наадамд 3-аас доошгүй айраг хүртсэн уяач нарт,

Аймгийн наадамд уяж, сойсон хурдан хүлэг морь нь түрүүлсэн тохиолдолд 2 айргаар тооцож, Үндэсний их баярын наадмын тухай хуулийн 8.4-д заасан болзол хангасан уяач нарт

#### **3.1.4. Аймгийн “Оны онцлох байгууллага”;**

Аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж буй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хамт олныг тухайн жилийн “Оны онцлох байгууллага”-аар шалгаруулж, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

“Оны онцлох байгууллага”-д нэр дэвшиж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь татвар, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өргүй, төсвийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлсэн, байгууллагын орчны тохижилт нь жишиг болохуйц, тухайн байгууллагын ажилтан, албан хаагчдаас гэмт хэрэг зөрчилд холбогдоогүй, хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажилладаг, аймаг, сумын ард, иргэдийн дунд хүлээн зөвшөөрөгдсөн байна

### **3.1.5. Аймгийн “Оны онцлох хүн”;**

Шинжлэх ухааны салбарт шинэ нээлт, бүтээл туурвисан, тэргүүний техник, технологийг нэвтрүүлсэн, орон нутгийн бүтээн байгуулалтад томоохон хөрөнгө оруулалт хийсэн, төрийн захиргаа, урлаг, спорт, боловсрол, эрүүл мэнд, байгаль орчин, хөдөө аж ахуй, дэд бүтцийн салбарт онцгой амжилт гаргасан иргэний тухайн онд гаргасан амжилтыг нь тус тус хэлэлцэн “Оны онцлох хүн”-ээр шалгаруулж, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

### **3.1.6.**

### **3.1.7. Аймгийн Засаг даргын “Жуух бичиг”;**

“Байгууллага, салбарын ой, бусад тэмдэглэлт өдрийг тохиолдуулан аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан, эрхэлсэн ажилдаа амжилт гаргаж, хамт олноо хошуучлан тухайн салбартаа 10-аас доошгүй, орон нутагт 8-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажилласан хүмүүсийг аймгийн Засаг даргын жуух бичгээр шагнана”

Аймгийн хөгжил, дэвшил болон гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхэд бодитой үнэтэй хувь нэмэр оруулж байгаа гадаадын иргэнийг аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнаж болно.

3.2. Дээрх шагналуудаас гадна Үндэсний Их баяр наадмын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4, 9 дүгээр зүйлийн 9.3-д заасны дагуу бөхчүүдэд “Начин”, “Заан”, “Харцага”, “Арслан” цол, харваачдад аймгийн “Мэргэн” цол олгох ба Үндэсний Их баяр наадамд амжилт үзүүлсэн бөх, уяач, харваачдад Монгол Улсын Засгийн газрын 2010 оны “Жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 271 дүгээр тогтоолын дагуу мөнгөн шагналыг олгоно.

3.3. “Онцгой гавьяа байгуулсан тохиолдолд аймгийн Засаг даргын шагналыг ажилласан жил харгалзахгүй олгож болно. Онцгой гавьяа гэдгийг хүний амь нас эрсдэхээс аварч хамгаалсан, байгалийн болон бусад гамшиг, ослын үед онцгой гавьяа байгуулан ажилласан гэж ойлгоно”.

3.4. Нэг төрлийн шагналыг давхардуулан олгохгүй.

## **ДӨРӨВ. ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ, ТОДОРХОЙЛОХ**

4.1. Шагналд нэр дэвшигч нь журмын гуравдугаар зүйлд заасан болзлыг хангасан байна.

4.2. Аймгийн Засаг даргын шагналаар шагнуулах санаачилгыг аймаг, орон нутгийн удирдлага, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээс гаргана.

4.3. Аймгийн Засаг даргын “Жуух Бичиг”, “Оны онцлох хүн” шагналд нэр дэвшүүлэхээр тодорхойлохдоо дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна. Үүнд:

4.3.1. Нэр дэвшигчийн анкет /хүснэгт 1/;

4.3.2. Нэр дэвшигчийн ажил байдлын тодорхойлолт;

4.3.3. Хамт олны хурлын тэмдэглэл;

4.3.4. Тухайн шагналаар шагнуулахыг дэмжсэн харьяалах төр болон төрийн бус байгууллагын албан бичиг

4.3.5. “Орон нутаг дахь төрийн байгууллагууд салбарын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтийн болон төрийн бус байгууллага, иргэдийг нэр дэвшүүлэхэд анхан шатны шалгаруулалтыг хийн аймгийн Засаг даргад шагналын материалыг уламжлан ирүүлнэ”

4.3.6. Шагналд нэр дэвшсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ажил байдлын тодорхойлолт нь үнэн зөв, ажлын үр дүн, гаргасан гавьяа зүтгэл, тухайн салбар, байгууллагын ажлын амжилтанд оруулсан хувь нэмэр нь тодорхой бөгөөд холбогдох судалгаа, тооцоогоор батлагдсан, байгууллагын дарга гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулсан байна.

4.4. “Оны онцлох байгууллага” шагналд нэр дэвшүүлж тодорхойлохдоо дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна. Үүнд:

4.4.1. Байгууллагын товч танилцуулга;

4.4.2. Байгууллагын тайлан /уг тайланд шагналын шалгуур үзүүлэлтэд дурдсан асуудлаарх байгууллагын гаргасан амжилт, ололтын талаар баримтжуулсан байна./;

4.4.3. Тухайн шагналаар шагнуулахыг дэмжсэн орон нутгийн дээд шатны байгууллагын албан тодорхойлолт;

4.4.4. Татвар, нийгмийн даатгал болон холбогдох байгууллагуудын албан бичиг;

4.5. Аймгийн “Аварга малчин”-ыг шалгаруулахаар тодорхойлохдоо дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна. Үүнд:

4.5.1. “Аймгийн аварга малчин”-д тодорхойлж байгаа өрхийн тэргүүний товч анкет /Энэхүү шагналын журмын 2, дугаар маягтын дагуу/;

4.5.2. “Аймгийн аварга малчин”-д тодорхойлж байгаа малчин өрхийн ажлын үзүүлэлт /Энэхүү шагналын журмын 3 дугаар маягтын дагуу/;

4.5.3. “Аймгийн аварга малчин”-д тодорхойлж байгаа малчин өрхийн ажлын үзүүлэлт, тодорхойлолтын баталгаа (энэхүү шагналын журмын 4 дүгээр маягтын дагуу)

4.6. Сумын Засаг даргын Тамгын газар нь сумын аварга малчин болсноос хойш 3-аас доошгүй жил амжилттай ажилласан, энэ журамд заасан шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа гурав хүртлэх малчин өрхийг аймгийн аварга малчинаар шалгаруулахаар тодорхойлно. Малчин өрхийн энэ журамд заасан шалгуур үзүүлэлтийг хангаж байгааг нотлох бичиг баримтыг сумын Засаг даргын тодорхойлолтын хамт жил бүрийн 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлнэ.

4.7. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь сумын ЗДТГ-аас ирүүлсэн аймгийн аваргад тодорхойлогдсон малчны холбогдох бичиг баримтыг хянан үзээд шаардлагатай бол газар дээр нь шалгаж, дүгнэлт гарган нэр дэвшигчдийн материалыг жил бүрийн Цагаан сарын шинийн 1-ний өдрөөс 20 хоногийн өмнө аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

4.8. Энэ журам батлагдахаас өмнө нь аймгийн сайн малчин, аймгийн аварга малчин өрх болж байсан малчныг “Аймгийн аварга малчин”-тай адилтган үзнэ.

4.9. Үндэсний Их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д заасан болзол хангасан уяачид “Аймгийн Алдарт уяач” цол олгуулах хүсэлтийг холбогдох баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Уяачдын холбооноос жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

4.10. Сумдын Засаг даргын Тамгын газар, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүд “Оны онцлох байгууллага”, “Оны онцлох хүн”-д нэр дэвшигчийн материалыг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

4.11. Аймгийн аварга малчин цолоор шагнагдсанаас хойш 3 жил дараалан өмнөх амжилтаа бататгасан малчныг улсын аварга малчинд тодорхойлж болно.

4.12. “Жуух бичиг” шагналд нэр дэвшигчдийн материалыг тухайн тэмдэглэлт өдрөөс ажлын 15 хоногийн өмнө аймгийн Засаг даргад ирүүлсэн байх шаардлагатай.

## **ТАВ. ШАГНАЛЫН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ, ОЛГОХ**

5.1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс нь аймгийн Засаг даргын шагналд тодорхойлсон шагналын материалын бичиг баримтын бүрдлийг, холбогдох бодлогын хэлтсүүд шагналд нэр дэвшигчдийн шагнуулах үндэслэл, тодорхойлолтыг хянан үзэж, дор дурдсан хугацаанд шагналын материалыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар тус тус хэлэлцүүлнэ. Үүнд:

5.1.1. Аймгийн “Аварга малчин”, “Алдарт уяач”-д нэр дэвшигчдийн материалыг жил бүрийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор;

5.1.2. Аймгийн “Оны онцлох хүн”, “Оны онцлох байгууллага”-д нэр дэвшигчийн материалыг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор;

5.1.3. “Хүндэт дэвтэр”-т бичих болон “Жуух бичиг”-ээр шагнах асуудлыг тухай бүр;

5.2. Аймгийн Засаг даргын “Жуух бичиг” шагналыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, “Оны онцлох байгууллага”, “Оны онцлох хүн”, аймгийн “Аварга малчин”, “Алдарт уяач” шагналыг Тамгын газрын холбогдох бодлогын хэлтсүүд аймгийн Засаг даргын зөвлөлийн

хуралдаанаар хэлэлцүүлэх ба шагналын олгох асуудлыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс тус тус хариуцна.

5.3. “Аймгийн “Аварга малчин”, “Алдарт уяач” шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгэнд малчид, уяачдад гардуулан өгнө.

5.4. “Оны онцлох хүн”, “Оны онцлох байгууллага” шагналыг аймгийн Шинэ жилийн нэгдсэн арга хэмжээн дээр гардуулна.

5.5. Аймгийн Засаг даргын шагналд дагалдах мөнгөн шагнал болон үнэ бүхий зүйлийн мөнгөний хэмжээ, олгох хүний тоо:

№	Шагналын нэр	Олгох шагналын хэмжээ	Жилд олгох хүний тоо
1	“Хүндэт дэвтэр”-т бичигдсэн тухай дурсгалын гэрчилгээ	300 000 төгрөг	Болзол хангасан тохиолдолд
2	Аймгийн “Аварга малчин” цол, тэмдэг	1 000 000 төгрөгийн үнэ бүхий дурсгалын зүйл	10 хүртэл
3	Аймгийн “Алдарт уяач” цол, тэмдэг	1 000 000 төгрөгийн үнэ бүхий дурсгалын зүйл	Болзол хангасан тохиолдолд
4	Аймгийн “Оны онцлох байгууллага”	500 000 төгрөг	3 хүртэл /Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага тус бүрээс 1/
5	Аймгийн “Оны онцлох хүн”	200 000 төгрөг	6 хүртэл
6	Аймгийн Засаг даргын “Жуух бичиг”	50 000 төгрөг	-

5.6. Шагналд зарцуулагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулна.

## ЗУРГАА. БУСАД

6.1. Аймгийн Засаг даргын Тамгын газар нь аймгийн Засаг даргын шагналаар шагнагдсан иргэдийн талаар мэдээллийн сантай байх ба санг шагналын төрөл, олгосон хугацаа, огноогоор төрөлжүүлсэн байна.

6.2. Мэдээллийн сангийн бүрдүүлэлт, баяжилт хөдөлгөөн болон аймгийн Засаг даргын шагналд тодорхойлж ирүүлсэн шагналын материалуудыг буцаан хүргүүлэх болон шагнагдагсдын материалыг оны эцэст архивт хүлээн өгөх ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс хариуцна.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ  
ШАГНАЛД НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ АНКЕТ

1. Овог нэр .....

2. Төрсөн, он, сар, өдөр .....

3. Регистрийн дугаар .....

4. Хүйс .....

5. Төрсөн аймаг, хот, /сум, дүүрэг/.....

6. Оршин суугаа газрын хаяг .....

6. Боловсрол, мэргэжил .....

7. Ажил эрхлэлтийн байдал .....

Цээж зураг  
/3x4/-ийн  
хэмжээтэй

№	Ажлын газрын нэр	Хугацаа	Эрхэлсэн ажил

8. Ажилласан хугацаа

Нийт ..... жил, үүнээс: Говьсүмбэр аймагт ..... жил, тухайн салбарт .....  
жил,

тухайн хамт олны дотор ..... жил.

9. Шагнагдсан байдал .....

10. Нэр дэвшиж байгаа шагналын төрөл:

11. Шагнуулах үндэслэл:

Тодорхойлсон байгууллагын эрх бүхий  
албан тушаалтны нэр, гарын үсэг

...../

/Тамга/

**“АЙМГИЙН АВАРГА МАЛЧИН”-Д ТОДОРХОЙЛЖ БАЙГАА ӨРХИЙН  
ТЭРГҮҮНИЙ ТОВЧ АНКЕТ**

Цээж зураг  
/6x4/  
өнгөт

..... он ..... сар ..... өдөр

1.	Сум, багийн нэр	
2.	Ургийн овог (эхнэр, нөхөр)	
3.	Эцгийн (эх) нэр	
4.	Нэр	
5.	Төрсөн он, сар, өдөр, нас, хүйс	
6.	Боловсрол	
7.	Ам бүлийн гишүүдийн тоо	
8.	Улсад ажилласан жил	
9.	Үүнээс малчнаар ажилласан жил	
10.	Сумын аварга малчин өрхөөр шалгарсан үнэмлэхийн дугаар огноо	
11.	Шагнагдсан төрийн одон, медаль огноо	



“Аймгийн Засаг даргын шагналын  
журам”-ын 3 дугаар маягт

**“АЙМГИЙН АВАРГА МАЛЧИН”-Д ТОДОРХОЙЛЖ БАЙГАА  
..... СУМЫН МАЛЧИН ӨРХИЙН АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ**

..... он ..... сар ..... өдөр

Үзүүлэлт	Малын төрөл	Онууд		
		.... он	.... он	.... он
Нэг. Малын төрөл, тоо				
Малын үүлдэр, омог (тэмээ.....үүлдэр, омог, адуу ..... үүлдэр, омог, үхэр..... үүлдэр, омог, хонь..... үүлдэр, омог, ямаа.....үүлдэр, омог)				
1. Оны эхний мал бодод шилжүүлснээр	Бүгд			
2. Оны эхний мал				
Үүнээс:	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
3. Хээлтэгч	Бүгд			
Үүнээс:	Ингэ			
	Гүү			
	Үнээ			
	Эм хонь			
	Эм ямаа			
4. Хээлтүүлэгч	Бүгд			
Үүнээс:	Буур			
	Азарга			
	Бух			
	Хуц			
	Ухна			
5. Бойжуулсан төл	Бүгд			
Үүнээс:	Ботго			
	Унага			
	Тугал			
	Хурга			
	Ишиг			
6. Зах зээлд борлуулсан мал	Бүгд			
Үүнээс:	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
7. Үржилд худалдсан мал	Бүгд			
Үүнээс:	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			

	Ямаа			
8. Малжуулахад өгсөн мал	Бүгд			
Үүнээс:	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
9. Ядуурал бууруулах үйлсэд оролцсон бусад үйл ажиллагаа /оруулсан хөрөнгө мян.төг/				
10. Өөрийн хэрэгцээнд хэрэглэсэн мал	Бүгд			
Үүнээс:	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
11. Оны эцэст тоологдсон Мал	Бүгд			
Үүнээс:	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
12. Оны эцэст байгаа Хээлтэгч	Бүгд			
Үүнээс:	Ингэ			
	Гүү			
	Үнээ			
	Эм хонь			
	Эм ямаа			
13. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо	Буур			
	Азарга			
	Бух			
	Хуц			
	Ухна			
Хоёр. Ашиг шим ашиглалтын байдал				
14. Оны эхний нэг малаас үйлдвэрлэсэн мах (кг-аар)	Бүгд			
Үүнээс:	Тэмээний мах			
	Адууны мах			
	Үхрийн мах			
	Хонины мах			
	Ямааны мах			
15. Нийт бүтээгдэхүүн Үйлдвэрлэлт	Мах үйлдвэрлэл (кг)			
	Тэмээний ноос (кг)			
	Хонины ноос (кг)			
	Ямааны ноолуур (кг)			
	Цагаан идээ (кг)			
	Сүү (литр)			

орлого (мянган төгрөг) Үүнээс:	Мал амьдаар борлуулснаас			
	Мах борлуулснаас			
	Ноос борлуулснаас			
	Ноолуур борлуулснаас			
	Цагаан идээ борлуулснаас			
	Сүү борлуулснаас			
	Арьс борлуулснаас			
	Шир борлуулснаас			
	Бусад			
	Өвс			
17. Өрхийн хэмжээнд бэлтгэсэн өвс, гар тэжээл, хүчит тэжээл, хужир (тн)	Гар тэжээл			
	Хүчит тэжээл			
	Хужир			
18. Хашаа	Хашааны тоо			
	Багтаамж (толгой мал)			
19. Худаг	Худгийн тоо			
	Хүчин чадал (л/сек)			
20. Хөрөнгө оруулалт (мянган төгрөг)	Худаг			
	Малын хашаа, хороо			
	Бэлчээр сайжруулах			
21. Татвар төлөлт (ХХОАТатвар)	Хадлангийн талбай хамгаалах			
	Төгрөгөөр			
22. Малын тоо толгойн албан татвар төлөлт	Төгрөгөөр			
23. Малын индексжүүлсэн даатгал	Даатгуулсан малын тоо			
	Төлсөн хураамж			
24. Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	Төгрөгөөр			
25. Нийгмийн даатгалын шимтгэл	Төгрөгөөр			

Тайлбар: Дээрх үзүүлэлтүүдийг улсын тооллого, бусад холбогдох цахим сангаас татсан тайлан, материалыг үндэслэн баталгаажуулна.

----- аймаг ----- сумын Засаг дарга -----/...../

Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн -----/...../

**“АЙМГИЙН АВАРГА МАЛЧИН”-Д ТОДОРХОЙЛЖ БАЙГАА  
..... СУМЫН МАЛЧИН ӨРХИЙН АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ,  
ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГАА**

..... он ..... сар ..... өдөр

Аймгийн аварга малчин цолд тодорхойлж байгаа малчин өрх дараахь бичиг баримтыг  
бүрдүүлж ирүүлнэ:

1. Малчин өрхийн ажил байдлын тодорхойлолт
2. Багийн Засаг даргын тодорхойлолт
3. Иргэний үнэмлэхний хуулбар
4. Малчин өрхийн малын А данс Сумын төрийн сангийн төлөөлөгчийн тодорхойлолт (мал тооллогын программаас татсан /жилээр/)
5. Туслах малчин тус бүртэй байгуулсан гэрээний хуулбар, туслах малчинд олгосон цалингийн банкны гүйлгээний баримт
6. Малжуулах зорилгоор олгосон малын төрөл, нас, хүйс, малжуулсан өрхийн жагсаалтыг сүүлийн 3 жилээр гаргасан сумын ЗДТГ-ын даргын тодорхойлолт
7. Бэлчээрт хөрөнгө оруулалт хийсэн хөрөнгийн хэмжээ /Сумын ХААТасгийн тодорхойлолт/
8. Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн мэдээлэл, ялган төвлөрүүлсэн богийн хээлтүүлэгчийн тоо / Сумын ХААТасгийн тодорхойлолт/
9. Малчин малын тоо толгойн албан татварыг төлсөн тухай цахим системийн хуулбар
10. Малын эрүүл мэндийн дэвтрийн хуулбар;
11. Сумын Мал эмнэлгийн тасгийн тодорхойлолт;
12. Малчин өрхийн гишүүдийн нийгмийн даатгалд хамрагдсан байдал /E-Mongolia цахим системийн тодорхойлолт/
13. Малчин өрхийн гишүүдийн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал /E-Mongolia цахим системийн тодорхойлолт/
14. Малын индексжүүлсэн даатгалын гэрээний хуулбар, мөнгө төлсөн баримт;
15. Бэлчээр ашиглалтын зөрчил гаргаагүй тухай баримт / Сумын байгаль орчны улсын байцаагчийн тодорхойлолт, сумын цагдаагийн тодорхойлолт/
16. Сумын аварга малчин цолны үнэмлэхийн хуулбар;
17. Багийн иргэдийн Нийтийн Хурлын тэмдэглэл;
18. Сумын Засаг даргын албан хүсэлт;
19. Аймгийн ХХААГазрын шалгаруулалт хийсэн тухай дүгнэлт;

Тайлбар:

1. Холбогдох баримтыг хавсаргаагүй бол баталгаа хүчингүйд тооцогдоно.
2. Дээрх хавсралтад заасан үзүүлэлт бүрээр баталгаа гаргана.

-----сумын Засаг дарга -----/...../